



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 3 сарын 4-ний өдөр

То №1

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 76.1.11 дэх заалт, “Монгол Базалт” ХК-ийн дүрмийн 6.2.6.5 заалт, компанийн 2019 оны 3 сарын 4-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базалт” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хавсралтаар баталсугай.
2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хувыцаа эзэмшигчдийн ээлжит хурал хэлэлцүүлсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л. АРИУНБОЛД



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 3 сарын 4-ний өдөр

То №2

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 76.1.2, 76.1.3 дах заалт, 60 дугаар зүйл 60.1, 60.2-д заалтууд, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийг 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Монгол базальт” ХК-ийн дүрмийн 6.2.6.3, 6.2.6.4 заалтууд, 2019 оны 3 сарын 4-ны өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын хурлын танхимд зарлан хуралдуулахаар тогтсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр шийдвэрлүсэй.
 1. “Монгол Базальт” ХК-ийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох,
 3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулалын хэмжээг тогтоох,
 4. Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх.
 5. Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
4. “Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2019 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн

өөрийн цахим хуудас, өдөр тутмын нэг сонинд, радио болон телевизийн аль нэгээр мэдээлсүгэй.

5. Хурлын давтан зарыг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу өдөр тутмын сонин болон радио телевизийн аль нэгнээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигч нь энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 11⁰⁰-16⁰⁰ цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, “Фламинго Тауэр” 7 давхарт ирж танилцаж болохыг дурьдсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар материал, 1 дүгээр хавсралтанд заасан баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөр тогтсугай.
8. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг 2 дугаар хавсралтаар баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 14 цаг байхаар тогтсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар компанийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэл, хурал зохион байгуулах комиссын гишүүдээр “Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Амарбаясгалан, менежер Г.Сугархүү нарыг тус тус томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар “Монгол Базальт” ХК-ийн хяналтын ажилтан Ж.Байгальмаа, тооллогын комиссын гишүүнээр “Монгол Базальт” ХК-ийн төсөвчин Б.Төмөртоогоо, “Монгол Базальт” ХК-ийн эдийн засагч Ж.Чулуунбат нарыг тус тус томилсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л. АРИУНБОЛД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн жагсаалтууд:
1	“Монгол Базальт”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар
2	Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичиг.Үүнд:
	1. “Монгол Базальт”ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
	2. Аудитын дүгнэлт
	3. Саналын хуудас
	4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоол шийдвэрийн төсөл
	5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал
	6. “Монгол Базальт”ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн №4 тоот тогтоол “Ногдол ашиг нэмэгдүүлэн хуваарилах тухай”

**“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Регистерийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн / Үнэт цаасны компани /

Брокерийн овог нэр

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 сарын 29-ны
өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, ерөнхий сайд Амарын гудамж,
Туушин зочид буудлын хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах			
2.	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай			
3	Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх эсэх тухай			
4	Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг батлах			

(Та саналыг хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдэгийг бичнэ үү)

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг

Брокер Гарын үсэг
/ тэмдэг /

2019 оны..... сар.....өдөр

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.
3. Засварласан болон балласан, давхардсан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 99010166 утсаар лавлаж болно.

Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан

Тооллогын комиссын дарга:

Тооллогын комиссын гишүүн:

**“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистерийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо Кумулятив саналын тоо.....

Бүртгэсэн / Брокер диллерийн компани /

Брокерийн овог нэр

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 сарын 29-ны
өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, ерөнхий сайд Амарын гудамж,
Туушин зочид буудлын хурлын танхимд болно.

№	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
Ердийн гишүүд:		
1		
2		
3		
4		
5		
6		
7		
Хараат бус гишүүд:		
1		
2		
3		

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг

Брокер Гарын үсэг
/ тэмдэг /

2019 оны сар..... өдөр

Саналын хуудас бөглөх санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Кумулятиваар аргаар таны санал өгөх эрхийн нийт тоо нь таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор буюу 9-өөр үржүүлсэнтэй тэнцүү байна. **Жишээ нь:** та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу. Хувьцаа эзэмшигч та саналын тооноос давсан санал өгөхгүйг анхаарна уу. Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан

Тооллогын комиссын дарга:

Тооллогын комиссын гишүүн:



“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 3 сарын 4-ний өдөр

То №3

Улаанбаатар хот

Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх эсэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.7 дэх заалт, 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2 заалт, компанийн 2019 оны 3 сарын 4-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-д заасны дагуу “Монгол Базалт” ХК нь өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах, компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх эсэх тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, батлуулсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л. АРИУНБОЛД



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 3 сарын 4-ний өдөр

То №4

Улаанбаатар хот

“Монгол Базальт” ХК ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэн хуваарилах тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6, 46.8 заалтууд, 76 дугаар зүйлийн 76.1.12 заалт, “Монгол Базальт” ХК –ийн 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2018 оны цэвэр ашгийн 86%-ийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэж, нэгж хувьцаанд 3 төгрөг 30 мөнгө /гурван төгрөг гучин төгрөг/ -ний ногдол ашиг тараахаар тогтсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтсугай.
3. “Монгол Базальт” ХК-ийн үүсгэн байгуулагч, компанийн нийт хувьцааны 70%-ийн хувьцааг эзэмшигч нэр бүхий таван (Л.Ариунболд, А.Энхгэрэл, П.Сайнбилэг, А.Энхжин, А. Энхмаа) хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тэдгээрийн ногдол ашгийг 2019 оны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтанд зарцуулж, компани төлөвлөсөн хөрөнгө оруулалт хийж дуусгах хүртэл хугацаагаар ногдол ашгийг олгохыг хойшлуулахыг зөвшөөрсүгэй.
4. “Монгол Базальт” ХК-ийн 5 хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг өглөг үүсгэн нягтлан бодох бүртгэлд тусгахыг Ерөнхий нягтлан даалгасугай.
5. “Монгол Базальт” ХК-ийн дээрхи нэр бүхий таван хувьцаа эзэмшигчдээс бусад хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг ҮЦТХТ дэх дансанд 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд компанийн мөнгөн урсгалын харгалзан ҮЦТХТ-тэй гэрээ байгуулан ногдол ашгийг тараасугай.
6. “Монгол Базальт” ХК-ийн 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн ТУЗ-ийн хурлын 2 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД